TransBank
ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК

ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2026 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН Б.ОЮУНЦАЦРАЛ

2026 оны 09 сарын 15
Улаанбаатар хот

Тээвэр хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Б.Оюунцацрал миний бие 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн тус банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний хувьд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "Компанийн тухай хууль, Банкны тухай хууль" болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан "Банкны Зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам", "Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам", Тээвэр хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон Банкны Дүрмийг тус тус мөрдөж хэрэгжүүлэн ажилласан болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон байдал

Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь 2026 оны 03 дугаар улирал буюу 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд 2 удаа хуралдаж нийт 8 асуудлыг хэлэлцсэн бөгөөд дараах асуудлуудыг шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон болно. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 сарын 17-ны өдрийн №Т/26-09 дугаартай хурлаар:

1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн даргатай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний хугацааны талаарх асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Тус асуудлыг хэлэлцсэний хүрээнд Тээвэр хөгжлийн банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2026 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 14 цаг 00 минутад банкны төв байрны 15 давхарт "Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн даргатай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний хугацааны талаар хэлэлцүүлэн хуралдуулахаар шийдвэрлэв.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 09 сарын 30-ны өдрийн №Т/26-10 дугаартай хурлаар:

1. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын хурлын санал, дүгнэлтийг танилцуулах тухай
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын хурлаас Гүйцэтгэх удирдлагад өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн байдлыг нэгтгэн танилцуулах тухай

3. Банкны их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тайлан танилцуулах тухай
4. Хөндлөнгийн аудитын байгууллага сонгох саналын тогтоолын төслийг хэлэлцэх тухай
5. Банкны Гүйцэтгэх захирлын өргөдлийг хэлэлцэх, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийг томилох, Гүйцэтгэх захирлын албан тушаалд нэр дэвшүүлэх талаарх тогтоолын төслүүдийг тус тус хэлэлцэх тухай
6. Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн даргатай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж буй асуудал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Баттүшигийн ирүүлсэн өргөдлийн талаар тус тус хэлэлцүүлэхээр банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тогтоолын төслийг хэлэлцэх тухай
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгон томилох тогтоолын төслийг хэлэлцэх тухай

Дээрх асуудлуудыг хэлэлцэж дараах шийдвэрүүдийг тус тус гарган ажилласан.

Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын хурлын санал, дүгнэлттэй танилцав.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын хурлаас Гүйцэтгэх удирдлагад өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн байдалтай танилцав.
- Банкны 2026 оны 1, 2 дугаар улирал, 7, 8 дугаар саруудын их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тайлантай танилцав.
- Банкны 2026-2027 онуудын жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээг Хөндлөнгийн аудитын байгууллага болох “Пи Кэй Эф-Ай Эй Эс Аудит” ХХК-иас авч, холбогдох гэрээ байгуулахыг банкны Гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн бөгөөд 2027 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний гэрээний нөхцөлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулан, зохих зөвшөөрлийг авч гэрээ байгуулахыг банкны Гүйцэтгэх захиралд үүрэг болгов.
- Банкны Гүйцэтгэх захирал Батчулуун овогтой Эрдэнэбаяр /[redacted]/-ын ажлаас чөлөөлөгдөх хүсэлтийн дагуу түүнтэй байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г цуцалж, 2026 оны 10 дугаар сарын 01-

ний өдрөөр дуусгавар болгон Тээвэр хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлөхөөр шийдвэрлэв.

- Банкны Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр Энхбат овогтой Мөнхжаргал /[redacted]/-г 2026 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн томилж, банкны Гүйцэтгэх захирлын албан тушаалд нэр дэвшүүлэхээр шийдвэрлэж Монголбанкнаас зөвшөөрөл авахаар Э.Мөнхжаргалын холбогдох баримт бичгийг Монголбанканд хүргүүлэхээр шийдвэрлэв.
- Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Сэдванчиг овогтой Цэрэндаштай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний хугацаа дуусаж байгаатай холбоотой асуудал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Батсүрэн овогтой Баттүшигийн ирүүлсэн өргөдлийн талаарх асуудлыг тус тус банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар шийдвэрлэв.
- Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Сэдванчиг овогтой Цэрэндаш нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөгдөж байгаатай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Батчулуун овогтой Эрдэнэбаяр /[redacted]/-г 2026 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн сонгон томилохоор шийдвэрлэв.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын ажлыг хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд: Ажлын хэсгийн ахлагч: Х.Баттулга /Дотоод аудитын газрын захирал/ Гишүүд: С.Сайнжаргал /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/ Н.Түвшинжаргал /Үйл ажиллагаа хариуцсан захирал/ Г.Баярханд /Төлбөр тооцооны газрын захирал/
- Тус хурлаас гарах хурлын тэмдэглэл болон тогтоолыг зохих журмын дагуу Монголбанканд хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /С.Сайнжаргал/-д үүрэг болгов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хуралд оролцсон байдал /2026 оны 3 дугаар улирлын байдлаар/

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо нь **2026 оны 09 дүгээр сарын 21-ний** өдөр №АХ07/2026 дугаартай хуралдсан бөгөөд хорооны даргын хувьд хурлыг удирдан явуулсан.

Хорооны хурлаар нийт 5 асуудлыг хэлэлцэж холбогдох санал, дүгнэлтийг гарган албажуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд санал, дүгнэлтийг танилцуулж шийдвэрлүүлсэн. Хурлаар дараах асуудлыг хэлэлцсэн. Үүнд:

Аудитын хорооны 2026 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн №АХ07/2026 дугаартай хурлаар:

1. Банкны их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тайлан танилцуулах тухай
2. Хөндлөнгийн аудитын байгууллага сонгох саналыг хэлэлцэх тухай
3. Банкны Премиум салбарт хийсэн аудитын тайлан танилцуулах тухай
4. Банкны Сидар салбарт хийсэн аудитын тайлан танилцуулах тухай
5. Дотоод аудитын газрын 2026 оны эхний хагас жилийн ажлын тайлан танилцуулах тухай

Дээрх асуудлуудыг хэлэлцэж дараах санал, дүгнэлтүүдийг гарган Гүйцэтгэх удирдлагад болон Дотоод аудитын газарт тус тус хүргүүлж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд мөн танилцуулан хэлэлцүүлсэн. Үүнд:

- Банкны их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тайлантай танилцаж, тус тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулахаар шийдвэрлэв
- Хөндлөнгийн аудитын байгууллага сонгох саналын талаар хэлэлцэж Пи ки эф аудитын байгууллагыг сонгох саналыг дэмжиж тус асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.
- Банкны Премиум салбар болон Сидар салбаруудад хийсэн аудитын шалгалтын тайлантай танилцаж, харилцагчид банкны салбарт заавал өөрийн биеэр очихгүйгээр гүйлгээ хийх боломжуудыг судлах ажлыг дараагийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хурал дээр биелэлтийг танилцуулахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов.
- Мөн банкны салбаруудад алдаа дутагдал гарч байгаатай холбоотойгоор банкны хэмжээнд салбаруудын ажилтнуудад болон шинэ ажилтнуудад хийгдэж буй сургалтуудын талаарх мэдээллийг дараагийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хуралд танилцуулахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов.

- Тус хурлаас гарсан санал, дүгнэлтийг зохих журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /С.Сайнжаргал/-д үүрэг болгов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хуралд оролцсон байдал /2026 оны 3 дугаар улирлын байдлаарх/

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь 2026 оны 3 дугаар улирлын байдлаар 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хуралдсан бөгөөд нийт 5 асуудлыг хэлэлцэж холбогдох санал, дүгнэлтийг гарган ажилласан. Үүнд:

Эрсдэлийн удирдлагын 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн №ЭУХ/26-05 дугаартай хурлаар:

1. Банкны тусгай активын нэгжийн тайлан танилцуулах тухай
2. Банкны чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл танилцуулах тухай /2026.08.31-ний байдлаарх/
3. Банкны эрсдэлийн нэгдсэн тайлан танилцуулах тухай
4. Комплаенсийн газрын тайлан танилцуулах тухай /3 дугаар улирлын байдлаарх/
5. Европын Холбооны хориг арга хэмжээний талаар мэдээлэл өгөх тухай

Дээрх асуудлуудын хүрээнд тус хорооны хурлаас дараах санал, дүгнэлтийг гарган Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулахаар шийдвэрлэсэн.

- Банкны 2026 оны 2 болон 3 дугаар улирлын тусгай активын нэгжийн тайлантай танилцав.
- Банкны 2026 оны 8 дугаар сарын 31-ний байдлаарх чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн байдалтай танилцав.
- Банкны эрсдэлийн нэгдсэн тайлантай танилцав.
- Банкны комплаенсийн газрын 3 дугаар улирлын байдлаарх тайлантай танилцав.
- Европын Холбооны хориг арга хэмжээний талаарх мэдээлэлтэй танилцав.
- Тус хорооны хурлаас гарсан санал, дүгнэлтийг Гүйцэтгэх удирдлагад хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /С.Сайнжаргал/-д үүрэг болгов.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл ба их хэмжээний хэлцлийн тайлан

Монгол Улсын Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан байдаг.

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно. Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлагын багийн хооронд мэдээлэх процесс, ил тод байдал, шийдвэр гаргах талаар Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкны дүрэм, журам болон Тээвэр хөгжлийн банк ХК-ийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын дагуу хэвийн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүн Б.Оюунцацрал